

Ажлын хуудас 2

/ унших /

Байгалийн дүрслэлийг тоочин бичих

Алхам 1

Эхийг уншаад хүүгийн харсан зүйлийг өөрийн төсөөллөөр зураарай.

Бусдын тус багаддаггүй

Амьтан хүний улаан зам дээр хамаагүй засчихсан болжморын үүр. Үүрэнд гүрдгэр нарийхан хүзүүгээ өрсөлдөн сунгаж, эвэр шаргал амаа ангайн хоол горьдох, дөрвөн хөөрхөн ангаахай. Ангаахайнуудын хажуухан талд толгой нь эгц дээшээ цогнойсон метр хэрийн урт, цэвдэг эрээн могой. Могойн яг дээр дэлэм хүрэхтэй үгүйтэй зайд хий агаарт дүүжлэгдсэн мэт жиргэх ганц болжмор. Гайд өртсөн ганц нөхрөө аврах аргаа олж цөхөн, бусад нь дэмий л хойгуур урдүүр нь шумбан нисэж, нэг л жирийн бус шулганалдана.

Ийм нэгэн дүр зургийг хоньчин хүү гэнэт хараад, гайхан зогтусаж, эхлээд учрыг ухаарсангүй хэсэг зуур ажиглан харав...

(3. Далхжав)

Алхам 2

Байрлал заасан үгсийг утга тохирох үгтэй нь тохируулаарай.

